


Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



Ёс суртахуунтай байх зориг

Мөнх бус амьдралын маань зорилгуудын нэг нь ямар ч нөхцөлд Бурханд зарлигуудыг нь дагах болно гэдгийг нотлох явдал. Бид энэхүү сорилтыг сүнсний дэлхийд байхдаа давсан билээ. Гэвч мөнх бус амьдралын шалгалтанд унах магадлалтай байсан Тэнгэрийн эрхсийн гуравны нэг нь энэ төлөвлөгөөний эсрэг босон зогсов.

Бид энэ дэлхийд төрөхөөсөө өмнө Бурхан Эцэг, Түүний хүү Есүс Христийг биечлэн мэддэг байв. Тэд бидэнд зааж, зоригжуулж байхад бид Тэднийг харж мөн сонсож байсан. Харин одоо оюун ухаан, ой дурсамжийг маань нэгэн гивлүүр бүрхэж байгаа. Худал бүхний эцэг болох Сатанд биднийг мэхлэх давуу тал байгаа. Учир нь бид энэ дэлхийн зүйлсэд уруу татагдаж, бие махбодийн сул дорой чанаруудыг үзэж байх зуур зөвхөн итгэлийн нүдээр л хэн бэ гэдгээ харах ёстой болдог.

Энэ амьдралд эрч хүчийг бидэнд өгдөг агуу тусламжууд байдаг. Есүс Христийн Цагаатгал бол хамгийн агуу нь юм. Тэрээр үүнийг хийсэн учир бид баптисмын усанд нүглээ угааж, ариутгаж, гэрээ хийдэг. Бид ариун ёслолыг итгэлтэйгээр мөн гэмшсэн зүрх сэтгэлтэйгээр хүртэх аваас энэхүү гэрээгээ дахин шинэчилдэг.

Сүнслэг бэлгүүд нь бас нэгэн тусламж. Бид төрөх үедээ Христийн Сүнсийг хүлээж авдаг. Энэ нь мөнх

амьдрал уруу хөтлөх тэрхүү сонголтуудыг хийх хүч чадлыг өгдөг. Бид судруудыг Ариун Сүнсний тусламжтайгаар уншсанаар найдвартай хөтөчтэй болдог.

Залбиралдаа талархлаа илэрхийлж, тусламжийг тодорхой мөн итгэл найдвартайгаар хүсэн гуйхдаа, Түүн уруу эргэн очих үед эдлэх тэр баяр баяслыг, Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт байгаа мэт тэр мэдрэмжийг Ариун Сүнс бидэнд өгдөг. Энэхүү Бурхантай харьцах харьцаа нь бидний зүрх сэтгэл дэх айдсыг хөөн зайлуулж, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн хайр ба итгэлийг бий болгоход тусалдаг.

Ариун санваар нь бидний үйлчлэлд эрч хүчийг өгдөг. Ёслолуудаар дамжуулан үйлчлэх болон Сатаны нөлөөг давж гарах хүчийг хүлээж авдаг. Бид үйлчлэхээр дуудагдахад, Тэрээр бидэнд “Та нарыг хэн ч хүлээн авлаа гэсэн, тэнд Би тэрчлэн байх болно, учир нь Би та нарын нүүрний өмнө явах болно гэж амладаг. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно. Мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” (С ба Г 84:88).

Бошиглогч Иосеф Смит үйлчилж байхдаа айдастай байсан юм. Гэвч Бурхан түүнд Есүс Христийн жишээгээр дамжуулж эр зоригийг өгсөн юм.

“Мөн хэрэв чи нүхэнд, эсвээс алуурчдын гарт

чам дээр тохиох үхлийн яланд хаягдах ёстой аваас; хэрэв чи гүнд хаягдах аваас; хэрэв хүрхрэх далайн давалгаа чиний эсрэг хуйвалдах аваас; хэрэв догшин салхи чиний дайсан болох аваас; хэрэв тэнгэр хар барааныг цуглуулж, мөн бүх элементүүд замыг хүрээлэн хаахаар нэгдэх аваас; мөн бүхний дээгүүр, хэрэв тамын эрүү чиний араас амаа томоор ангайлгах аваас; эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно гэдгийг чи мэдэгтүн, хүү минь.”

“Хүний Хүү гэд бүгдэд доош бууж ирсэн юм. Чи түүнээс илүү агуу гэж үү?” хэмээн хэлсэн юм. (С ба Г 122: 7–8).

Бурхан бидэнд энэ амьдралд юутай ч учирсан тулалдах хангалттай эр зориг, хүчийг өгсөн. Хэрвээ бид Түүний тусламжийг хүсэх аваас, бидний эрэлхийлж буй мөнхийн амьдрал уруу Тэрээр биднийг чиглүүлэх болно.

ЭНЭХҮҮ ЗАХИАС БИЧГИЙН СУРГААЛ НЬ

Эзэн Багш Есүс Христ, хүмүүс Түүний заасан зарчмуудыг тунгаан бодож мөн хэрэгжүүлэхэд зоригжуулахын тулд байнга асуулт асуудаг байсан. Түүний асуултууд бодол төрүүлсэн, сүнсийг эрэлхийлсэн, мөн амлалт хүссэн байв” (*Teaching, No Greater Call [1999], 68*). Энэхүү захиас бичигт заасан үнэнийг ойлгож мөн ашиглахад нь хувь хүмүүст туслахын тулд хэд хэдэн асуулт зохиож мөн асуухад бэлтгэ. Жишээ нь: “Айдсаа хөөн зайлуулж, зоригтой байхын тулд Бурхан та нарт юу өгсөн бэ?” эсвэл “Айдсаа даван туулахад тань Бурхан хэрхэн тусалсан бэ?” гэж асууж болно. Тэднийг хариулахаасаа өмнө сайн тунгаан бодохыг сануул.

ЗАЛУУЧУУД

Төгс төгөлдөр хүн нэг ч байхгүй Шауна Скөүбий

Би Нифай шиг үргэлж дуулгавартай, маш итгэлтэй мөн сүнслэг нэгэн байхыг үргэлж хүсдэг байлаа. Минийхээр Нифай бол сайн

сайхны хамгийн тод үлгэр жишээ юм. Би түүнтэй адилхан болох бодлоос илүүтэйгээр түүний сайн чанарын нэг хэсгийг ч болов эхлүүлэх юмсан гэж бодсон юм.

Нэгэн өдөр өчүүхэн зүйлээс өөртөө итгэх итгэл алдарч сэтгэлээр уналаа. Би тавьсан зорилгуудаа биелүүлэхийг маш их хүсч байлаа. Гэвч би зорилгуудаа биелүүлж чадахгүй юм шиг санагдсан. Горьдлого тасарч, нүд дүүрэн нулимс-тайгаар энэ тухайгаа аавдаа хэллээ. Тэрээр номын тавиур дээрээс, Мормоны Номыг авлаа. Юу ч хэлэлгүйгээр, 2 Нифай 4:17-р шүлгийг уншиж эхлэв.

“Ай золгүй хүн юм би!” гэсэн хүчирхэг үгнүүдийг сонсож байхад цахилгаан мэт гүйдэл миний биеэр тархав. Би маш олон зүйлийн талаар бодож эхлэв. Миний баатар мөн жишээ болох Нифай яагаад өөрийгөө “золгүй” хэмээн хэлэв? Хэрвээ тэр золгүй байсан юм бол, би хэн болж байна?

“Бодгаль минь, сэр!” хэмээн аав минь 28-р шүлгийг үргэжлүүлэн унших үед цахилгаан гүйдэл дахин биеэр минь тархав. Дахин битгий нүгэлд гудай. Миний оюун ухаанд байсан хар үүл хөх тэнгэр, хурц нараар солигдох шиг л санагдсан. Энэхүү шүлэг миний бодгалыг хэрхэн гэрэлтүүлснийг тайлбарлах боломжгүй юм. Судрын энэ хэдхэн шүлэг надад итгэл найдвар, урам зориг, баяр баяслыг өгч чадсан.

30-р шүлэгт Нифай яг миний бодож байсан тэрхүү зүйлийг хэлсэн байна. “Миний сүнс танд баясна, Бурхан минь, мөн авралын минь хад билээ” хэмээх төгс ойлгомжтой үгсээр тайлбарлажээ. Энэхүү шүлэг Бурханы нигүүлсэл ба хайранд талархах амар амгалан мэдрэмжийг надад авчирсан.

Аав минь номоо хаагаад энэхүү шүлгийг заримдаа Нифайн дуулал хэмээн нэрлэдэг гэдгийг тайлбарласан юм. Аав минь энэ дэлхий дээрх агуу хүмүүс хүртэл төгс төгөлдөр биш гэдгийг мөн үүнийгээ үргэлж санаж явахгүй бол бардамнаж агуу нэгэн байхаа болино хэмээн надад заасан юм.

Би маш сайн ойлгосон. Надад байгаа сул дорой чанар Нифай шиг болох боломжгүй гэсэн

үг биш юм. Өөрийнхөө сул дорой чанаруудыг мэдэх нь намайг Нифайн чадварт илүү ойртуулж өгсөн. Нифай үнэхээр агуу. Учир нь тэрээр дуулгавартай, итгэлтэй байсан бөгөөд буруугаа хүлээн зөвшөөрөх чадвартай даруу нэгэн байсан.

Би энэ явдлаас хойш Нифайн үгсийг оюун ухаандаа нөөцөлсөн юм. Эдгээр шүлгийг унших бүрдээ би анх мэдэрч байсан тэр урам зоригийг мэдэрч, “Би бол Бурханы охин надад төсөөлдгөөс минь илүү боломж бий” гэдгийг олж мэддэг. Хэрвээ бид итгэлтэйгээр урагш тэмүүлэх аваас бидэнд зориулсан адислал бий гэдгийг би мэддэг.

ХҮҮХДҮҮД

Урам зориг өгдөг бэлгүүд

Ерөнхийлөгч Айринг бидэнд урам зориг өгдөг хэд хэдэн бэлгүүдийн талаар хэлж байна. Доорх шүлгүүдийг уншаад зайнд нь бэлгийн нэрийг бич. Гэр бүлийнхэнтэйгээ эдгээр бэлгүүд нь та нарт урам зоригийг хэрхэн өгдөг талаар ярилц.

1. Үйлс 22:16 _____
2. 2 Нифай 4:15 _____
3. С ба Г 59:8–9 _____
4. 2 Нифай 32:5; Иохан 14:26–27 _____
5. 1 Тесалоник 5:17 _____

Хувиараа судар судлах замаар Бурхан Эцэг болон Есүс Христэд ИТГЭХ ИТГЭЛЭЭ ХӨГЖҮҮЛЭХ НЬ



*Айлчилдаг эгч
нартаа эдгээр
судрын эшлэлүүдийг
болон тэднийг*

*адислахуйц бусад зарчмыг
заа. Сургаалын талаарх
гэрчлэлээ хуваалц. Эгч нараас
юу ойлгож, юу мэдэрснээ
хуваалцахыг хүс.*

“Би гэрлээд удаагүй байхдаа,
. . . Мормоны ном болон Сүмийн
түүхийн богинохон ном уншсан
тойргийнхоо Нийгмийн
Халамжийн Бүлгийн эгч нартай
өдрийн хоол идэхээр уригдсан
юм. Би судар уншихдаа
хайнга хандах болсон байлаа.
Тиймээс хялбар бөгөөд бага цаг
зарцуулах богино хэмжээний
ном уншин бүлгийн үдийн
хоолонд очихоор боллоо.
Би үдийн хоол идэж байхдаа
сүмийн түүх унших нь сайн
ч Мормоны Номоо унших
ёстой гэсэн хүчтэй мэдрэмжийг
мэдэрсэн юм. Судар унших
зуршлаа өөрчил хэмээх Ариун
Сүнсний мэдрэмжийг би хүлээн
авсан. Тэгээд яг тэр өдрөөс
эхлэн би Мормоны Номоо
уншдаг болсон бөгөөд түүнээс
хойш үргэлж уншдаг. . . Өдөр
бүр судраас уншсанаар би
Тэнгэрлэг Эцэг болон Түүний

Хүү Есүс Христийн тухай мөн
Түүнтэй адилхан болохын
тулд би юу хийх ёстой талаар
суралцсан. . . .

Эмэгтэй хүн бүр гэр бүлдээ
сайн мэдээний сургаалын
зааварлагч байж чадна.
Удирдагч болон багшийн
хувьд Сүмийн эгч бүрд сайн
мэдээний мэдлэг хэрэгтэй.
Хэрвээ та өдөр болгон
судар судалж хэвшээгүй бол
яг одооноос эхэл мөн энэ
амьдралд болон мөнхийн
амьдралд бэлтгэхийн тулд
үргэлжлүүлэн судал.”¹

**Жюли Б.Бек, Нийгмийн Халамжийн
Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч.**

“Судраас суралцах нь
бидний болон гэр бүлүүдийн
маань гишүүдийн гэрчлэлийг
хүчирхэгжүүлэхэд тусалдаг.
Хүүхдүүд маань өнөөдөр зөв
зорилготой байхаас татгалзаж,
дэлхийн зугаа цэнгэл уруу
татагдахуйц орчинд өсч бойжиж
байна. Тэдэнд Есүс Христийн сайн
мэдээ, үнэний тухай гэрчлэл, зөв
шударгаар амьдрах шийдвэр гаргах
бат бөх суурь байхгүй байсан бол
тэд муу нөлөөллүүдэд амархан
автах байсан. Тэднийг хамгаалж
мөн бататгах нь бидний үүрэг
хариуцлага мөн.”²

Ерөнхийлөгч Томас С.Монсон

АЙЛЧЛАГЧ БАГШИЙН ЗААЛТАД ЗОРИУЛСАН ТУСЛАМЖ

Айлчилж байх үедээ судар
ашиглан асуултанд хариулж
мөн бодол санаагаа хуваалц.
Судар судлах нь хэрхэн таны
итгэлийг хүчирхэгжүүлсэн
талаарх гэрчлэлээ хуваалц.
Эгч нараас судар судлах
нь хэрхэн түүний гэр бүл
болоод орон гэрийг нь
хүчирхэгжүүлсэн талаарх
сэтгэгдлээ хуваалцахыг хүс.

ХУВИЙН БЭЛТГЭЛ

Иохан 5:39

2 Тимот 3:14–17

2 Нифай 9:50–51; 31:2032:3–5

С ба Г 138:1–11

“Эгч нар маань судраас
суралцагчид байгаасай хэмээн
бид хүсч байна. . . . Өөрийнхөө
сайн сайхны төлөө, хүүхдүүддээ
заахын төлөө болон таны
нөлөөг мэдрэх бусад хүний
төлөө та нар Түүний мөнхийн
үнэнийг олж мэдэх хэрэгтэй.”³

“Та нар гэрлэсэн, ганц бие,
залуу, хөгшин, бэлэвсэн, гэр
бүлтэй байх нь хамаагүй бидний
гэр орон судар уншдаг эгч
нараар адислагдаасай хэмээн бид
хүсч байна. Судрын гарамгай

мэдлэгтэн болох нь бусдыг дорд
үзэх биш харин тэднийг өргөж,
туслахын тулд юм”⁴

**Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл
(1895–1985).**

ЭШЛЭЛ

1. “Миний зүрх сэтгэл судруудад баясдаг” Жюли Б.Бек, *Лиахона*, 2004 оны тавдугаар сар, 107–9.
2. “Таныг чиглүүлэх гурван зорилго” Ерөнхийлөгч Томас С.Монсон *Лиахона*, 2007 оны арваннэгдүгээр сар, 118.
3. “Эгч нарын үүрэг хариуцлага ба эрх” Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл *Ensign*, , 1979 оны 11-р сар 102.
4. Спенсер В.Кимбалл, “The Role of Righteous Women,” *Ensign*, 1979 оны 11- сар, 104.